






"Иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, үр дүн" гүйцэтгэлийн аудит

ХөААГ-/2017/03-ГА



**ДОТООД ХЯНАЛТ
ШАЛГАЛТААР ӨГСӨН
ЗӨВЛӨМЖИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЖ
АЖИЛЛААГҮЙ БАЙНА.**



АГУУЛГА		№
Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	3
Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын газар	Аудит хийх үндэслэл, зорилт, хамрах хүрээ, арга зүй	4
	Аудитад ашигласан хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт	5
Тайланг бэлтгэсэн:	Үндсэн мэдээлэл	5
ХөААГ-ын Нийцлийн аудитын баг		6
Тэргүүлэх аудитор Г.Оюунгэрэл Утас: 99909224 Аудитын менежер Г.Эрдэнэчимэг Утас: 99016320 Ахлах аудитор Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Шинжээч Э.Бат-эрдэнэ Утас: 99900662	Бүлэг 1. Батлагдсан бүтэц орон тооны хязгаарт багтаан ажиллаж, чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж байна.	6
	1.1. Удирдлага үндсэн үйл ажиллагаа, чиг үүргээ үр дүнтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлж ажилласан байна.	8
	1.2. Батлагдсан орон тоонд багтаан үйл ажиллагаагаа явуулж байна.	9
	1.3. Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, санхүүгийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж хэвшсэн байна.	
	1.4. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас хийсэн хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	
2017 оны 7 дугаар сар	Бүлэг 2. Иргэний, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хугацаанд нь үзүүлж хэвшсэн байна.	10
Уг тайланг ЯАГ-ын Веб сайт- аас үзнэ үү. www.audit.mn		12
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043 дугаарын утас, 70383793 дугаарын факсаар харилцана уу?	2.1 Иргэний, эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг хууль, журамд заасан хугацааны дотор бүртгэж хэвшсэн байна. 2.2 Үйлчилгээний хураамжийг тогтоосон хэмжээгээр ногдуулж, төвлөрүүлсэн байна.	20
ХАЯГ: (Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын А байр 3 давхарт)	3. ДҮГНЭЛТ 4. ЗӨВЛӨМЖ	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үг	Тайлбар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХөААГ	Хөвсгөл аймгийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ОӨУБЕГ	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар
УБСГ	Улсын бүртгэл, статистикийн газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын захиалга, Монгол Улсын Ерөнхий аудиторт Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үйлчилгээг чанартай хүргэж байгаа эсэхэд аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмжийг боловсруулахад аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтын хүрээнд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ.Үүнд:

- Удирдлага зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагаагаа үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлж ажилласан эсэх;
- Иргэний, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу чанартай, үр дүнтэй үзүүлж байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс болон бусад холбогдох байгууллагуудыг хамруулан иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой 2016 он, 2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, мэдээ, судалгаа холбогдох бусад баримт материалуудад тулгуурлан гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 3000-3100, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, ажиглалт хийх, харьцуулах, байгууллагын баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх, шалгадагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах болон аудитын бусад горимын дагуу нотлох баримт цуглуулан ажиллав. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд “Иргэний бүртгэл, мэдээллийн улсын сан”-г “Маш нууц”-ын жагсаалтад баталсан, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 18 дугаар зүйлийн 18.2-т эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримт, архивын хувийн хэрэг, баримттай улсын бүртгэгч, улсын ахлах бүртгэгч, улсын ерөнхий бүртгэгчээс бусад этгээд танилцах түүнд өөрчлөлт баяжилт хийхийг хориглосон тул аудитын баг МУ-ын ерөнхийлөгчийн 1999 оны 213 дугаар зарлигаар баталсан “МУ-ын төрийн нууцыг хамгаалах” журмын 3.1.2 дахь заалтын дагуу “нууцын баталгаа” гаргаж, аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2017 оны А/05 тоот тушаалаар баталсан ажлын хэсэгтэй хамтарч аудитыг хийж гүйцэтгэсэн.

Аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан тайлан бичиж холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлж байна.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль
- Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль
- Иргэний бүртгэлийн тухай хууль
- Төрийн нууцын тухай хууль
- Нууцын тухай хууль
- Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль
- МУ-ын ерөнхийлөгчийн 1999 оны 213 дугаар зарлигаар баталсан “МУ-ын төрийн нууцыг хамгаалах журам”
- Гэр бүлийн тухай хууль
- Иргэний хууль
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль
- Архивын тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журам, эрх зүйн актууд
- Бусад холбогдох хууль, тогтоомж

Бүлэг 1: Батлагдсан бүтэц орон тооны дотор ажиллаж, чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж байна.

Үндсэн мэдээлэл

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэний, эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд, чирэгдэлгүй хурдан шуурхай хүргэх чиг үүрэгтэй байгууллага юм. Засгийн газрын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй уялдуулан 2016 онд бүтэц зохион байгуулалтыг 2 удаа өөрчлөн баталсан байна. Үүнд:

1. Улсын бүртгэл, статистикийн газар
2. Улсын бүртгэлийн хэлтэс


Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, иргэний бүртгэлийн алба, эд хөрөнгийн бүртгэлийн алба, сумдын улсын бүртгэгч гэсэн бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. ОӨУБЕГ-ын даргын 2016 оны Б/37 тоот тушаалаар төрийн захиргааны албан хаагчдыг, Б/178 тоот тушаалаар төрийн үйлчилгээний албан хаагчдыг тус тус томилсон байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байна. 2016 он, 2017 оны эхний улирлын байдлаар батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг дараах байдлаар харуулж байна. Үүнд:

Онууд	Төлөвлөгөө /мян,төг/		Гүйцэтгэл /мян,төг/	
	Улсын төсвөөс	Үйл ажиллагааны орлогоос	Улсын төсвөөс	Үйл ажиллагааны орлогоос
2016 он	533502,3	296562,6	525803,9	296562,6
2017 оны 1 дүгээр улирал	119519,2	61876,4	119519,2	61900,9

ОӨУБЕГ-ын хяналт шалгалтаар 2016 онд иргэний бүртгэлийн чиглэлээр 123 бүртгэлийг шалгаснаас 34 бүртгэл алдаатай бүртгэгдсэн, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 240 бүртгэлийг шалгаснаас 13 бүртгэл алдаатай бүртгэгдсэн зөрчил тус тус илэрсэн байна. Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 34 бүртгэлийг шалгаснаас алдаатай бүртгэгдсэн зөрчил илрээгүй байна.

2016 он, 2017 оны эхний улирлын байдлаар иргэний эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр дараах үйлчилгээг үзүүлсэн байна.



1.1 Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс үндсэн үйл ажиллагаа, чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж ажилласан байна.

Улсын бүртгэлийн хэлтэс нь орон нутгийн хэмжээнд улсын бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх, тасгуудын ажлыг нэгтгэн, сум, тосгоны улсын бүртгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах, ажлын уялдаа холбоог зохицуулахад чиглэгдэж байна. 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө 6 зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж байгууллага өөрөө 100%-ийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас улсын бүртгэлийн хэлтсийн 2016 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж 75.1 хувиар үнэлсэн байна.

2017 оны эхний хагас жилд иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг хуулийн хүрээнд хурдан шуурхай, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэх зорилгоор дараах ажлуудыг удирдлагын зүгээс хийж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- “Угтах үйлчилгээний ажилтан”-г ажиллуулж улсын бүртгэлийн төрөл тус бүрээр иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч, бүрдүүлэх материалын талаар гарын авлага тарааж, мэдүүлэг, анкет бөглөх зэрэгт зааварчилгаа өгч ажиллаж байна.
- Мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж, цахим хуудас болон мэдээллийн самбарыг тогтмол шинэчлэн ажиллаж байна.

- Албан хаагчдыг мэдээ, мэдээллээр хангах, мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтын төлөвлөгөө боловсруулж эхний хагас жилд 6 удаагийн сургалт зохион байгуулсан байна.
- Иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгаа “нээлттэй хаалганы өдөр”-ийг аймаг болон сумдад зохион байгуулсан байна.

Аудитаар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, албан хаагчдын 2016 он, 2017 оны үр дүнгийн гэрээ, түүний биелэлт, ажилтнуудын хувийн хэргийг хянаж шалгахад дараах зөрчил дутагдал илэрч байна. Үүнд:

- Шинээр томилогдсон Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нь Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай 2016 онд үр дүнгийн гэрээ байгуулаагүй
- 2017 онд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нь ОӨУБЕГ-тай үр дүнгийн гэрээг байгуулж, харин аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж ажиллаагүй.
- Ажилтнуудын хувийн хэргийн бүрдэл дутуу, шаардлага хангахгүй байна.

Байгууллагын удирдлага үр дүнгийн гэрээ байгуулахгүй үйл ажиллагаа явуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1¹, 40.3² дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

Сумдын улсын бүртгэгчтэй гурвалсан гэрээ байгуулж, үр дүнг жил бүр үнэлж байгаа ч Мөрөн сумын 2 улсын бүртгэгчтэй гурвалсан гэрээг байгуулаагүй байна.

Мөрөн сумын улсын бүртгэгчид нь аймгийн “Улсын бүртгэлийн хэлтэс”-ийн байранд байрлаж үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд сум, багийн Засаг даргатай мэдээлэл солилцдоггүйгээс дараах хүндрэлтэй асуудлууд гарч байна. Үүнд:

- Мөрөн сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар шилжилт хөдөлгөөн болон овог нэр солих, асран хамгаалагч тогтоох, цэргийн бүртгэлтэй холбоотой үнэн зөв бодит мэдээллүүдийг авч чадахгүй байна.
- Сумын Засаг даргын захирамж гаргахдаа иргэний бүртгэлүүдийн анхан шатны баримт материалыг хянаж чадахгүй байна.

1.2 Батлагдсан орон тоонд багтаан үйл ажиллагаа явуулж байна.

Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн бүтэц орон тоог 2016 онд дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Хүснэгтээр харуулбал:

2016 оны батлагдсан орон тоо

Хүснэгт-1

Байгуулл агын нэр	Орон тоо баталсан тушаал	Төрийн захиргааны ажилчид	Гэрээт албан хаагч	Нийт
УБСГ	УБСГ-ын даргын 2016.03.04.- Б/68	49	0	56
	УБСГ-ын даргын 2016.03.28 – Б/104	0	7	
УБХ	ОӨУБЕГ-ын даргын 2016.09.14- Б/37	43	0	47
	ОӨУБЕГ-ын даргын 2016.09.14- Б/178	0	4	

Хүснэгтээс харахад 2016 онд Улсын бүртгэлийн, статистикийн ерөнхий газар нь Улсын бүртгэлийн хэлтэс, Статистикийн хэлтэс гэсэн бүтэцтэй 56 орон тоотой ажиллаж байсан ба Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн

¹ Төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяалагдах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна.

² Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ.

Улсын бүртгэлийн хэлтсийг Иргэний бүртгэлийн, Эд хөрөнгийн бүртгэлийн гэсэн 2 тасаг, сумдын улсын бүртгэгч нийт 47 орон тоо, бүтэцтэй байхаар дахин шинэчлэн баталсан байна.

2017 оны 5 сарын байдлаар нийт 44 орон тоогоор ажиллаж байгаа ба 3 ажилтан хүүхэд асрах чөлөөтэй байна.

Нийт албан хаагчдын мэргэжил боловсролын судалгааг хянахад ажлын байрны тодорхойлолтод заагдсан дээд боловсролтой, эрх зүйч болон бусад мэргэжилтэй гэсэн үндсэн шаардлагуудыг хангаж байна.

Нийт улсын бүртгэгчдийн ажлын байрны тодорхойлолтод заасан **“улсын бүртгэгчийн сургалтад суусан байх”** гэсэн шаардлагыг нийт улсын бүртгэгч нарын 91,8% нь хангахгүй байна.

1.3. Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, санхүүгийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж байна.

Тус хэлтсийн төсвийн шууд захирагч нь 2016 тайлант онд улсын төсвөөс 533502,3 мянган төгрөгийн санхүүжилт авч 525803,9 мянган төгрөгийн гүйцэтгэлээр зарцуулсан байна. 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

2016 оны санхүүгийн тайлангаас бараа материал, хичээл үйлдвэрлэл, шуудан холбоо, дотоод албан томилолт, тээвэр шатахууны зардал зэргийг түүвэрлэн шалгахад дараах зардалд зөрчил илэрлээ. Үүнд:

Дотоод албан томилолтын зардал: 2016 онд нийт 2968,1 мянган төгрөгийн томилолтын зардлыг зарцуулж байна. Томилолтын зардлыг олгохдоо томилолтоор явсан ажлын удирдамж, гүйцэтгэсэн ажлын тайланг үндэслэн олгоогүй, албан томилолтын хуудсыг бүрэн таглаагүй байхад томилолт олгогдсон зэрэг зөрчил илэрлээ.

2017 оны тухайд: 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын төсвөөс нийт 119519,2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 61900,9 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч зарцуулсан байна.

Зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2:/мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Урсгал зардал	181395,6	176293,5	5102,1
Бараа үйлчилгээний зардал	119519,2	114417,1	5102,1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97083,9	93345,8	3738,0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10679,1	10679,1	0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7468,5	7468,5	0
Хангамж бараа материалын зардал	2753,4	2113,3	640,1
Эд хогшил худалдан авах зардал	367,4	231,9	135,5
Томилолт зочны зардал	500,0	486,0	14,0
Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр	419,5	92,4	327,1
Бараа үйлчилгээний бусад	247,4	0	247,4
Урсгал шилжүүлэг	61876,4	61876,4	0

Аудитаар санхүүгийн анхан шатны баримт материал, нягтлан бодох бүртгэлийн үнэн бодит байдлыг хянаж үзэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно. Батлагдсан төсвийг зардлын зүйл анги тус бүрээр зарцуулсан байна.

Тус байгууллагын бүртгэлийн үйлчилгээний хураамж, үнэт цаасны тооцоог хянаж үзэхэд дараах байдалтай байна.

№	Үзүүлэлт	2016 он	2017-03 сар
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	296,5	62,5
2	Тэмдэгтийн хураамж	42,6	12,4

Үйл ажиллагааны орлого буюу үйлчилгээний хураамжийг Засгийн газрын 2010 оны 237

дугаар тогтоолоор батлагдсан “Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээ”-г тооцох тухай журамд заасан хувь хэмжээгээр Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт төвлөрүүлж байна. Тэмдэгтийн хураамжийг орон нутгийн орлогын дансанд шууд төвлөрүүлж, сар бүр нягтлан бодогч сумдын улсын бүртгэгч нартай тооцоо нийлсэн байгаа ч аудитын түүвэрт хамрагдсан иргэний, эд хөрөнгийн улсын бүртгэлийн хувийн хэргийг хянаж үзэхэд 1403.4 мянган төгрөгийн бүртгэлийн хураамжийг буруу тооцож авсан зөрчил гарч байна.

Үнэт цаасны тооцоог 2016 он, 2017 оны эхний улирлын байдлаар хянаж үзэхэд зөрчил илрээгүй болно.

1.4. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд тавих хяналт нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 10.1³, Иргэний бүртгэлийн тухай хуулийн 38.1⁴-дэх заалтууд болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2015 оны 1811 дүгээр тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журам”-аар зохицуулагдаж байна. Аймгийн “Улсын бүртгэлийн хэлтэс”-ийн хяналтын улсын байцаагчаар 2016 онд Б.Мөнхзул, 2017 онд Д.Чимэдцогзол нар ажилласан байна.

Хяналтын байцаагчийн үйл ажиллагаа нь ОӨУБЕГ-ийн хяналт үнэлгээгээр Иргэн, хуулийн этгээдийн хяналт шалгалтын тоо бага, иргэний бүртгэлийн чиглэлээр алдаатай бүртгэлийн тоо их байх магадлалтай, нийт бүртгэлийн 27,6% нь алдаатай байх эрсдэлтэй гэж дүгнэсэн байна.

2017 оны эхний хагас жилд хяналтын байцаагч нь нийт сумын 79,2%-д нь хяналт хийх, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 480 бүртгэлд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 360, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 360 бүртгэлд хяналт хийхээр төлөвлөсөн байна.

Дотоод хяналтыг 2016 онд 31 удаа, 2017 оны эхний хагас жилийн байдлаар 23 сумдын улсын бүртгэлтэй холбоотой баримт материалыг татан хяналт хийж зөрчлийг арилгах албан шаардлагыг сумдад хүргүүлэн ажиллаж байна.

Хяналт хийснийг хүснэгтээр харуулбал: Хүснэгт 3:

Улсын бүртгэлийн чиглэл	2016 он	2017 оны эхний хагас жил
-------------------------	---------	--------------------------

³ “Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлт, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлнэ”.

⁴ Иргэний бүртгэлтэй холбогдсон хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, зааврыг тус улсын нутаг дэвсгэрт байгаа нийт иргэн, байгууллага хэрхэн сахин биелүүлж байгаад иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

	Бүртгэлийн н тоо	Зөрчил	Бүртгэлийн н тоо	Зөрчил
Иргэний бүртгэл	140	16	190	19
Хуулийн этгээдийн бүртгэл	100	14	120	2
Эд хөрөнгийн эрхийн бүртгэл	120	6	150	0
Нийт	360	36	460	21

Хүснэгтээс
харахад улсын
бүртгэлийн чиглэл
бүр дээр
түүвэрлэсэн
хяналтын тоо өсөх
тусам зөрчил буурч
байгаа нь хяналт үр

дүнгээ өгч байгааг харуулж байгаа мэт боловч 2016 он, 2017 оны эхний улиралд үзүүлсэн нийт үйлчилгээний 10 хүрэхгүй хувьд түүвэр хяналт шалгалт хийхэд тодорхой зөрчил дутагдлууд байсаар байна.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас хийсэн хяналт шалгалтаар 6 зүйл зөвлөмжийг хүргүүлсэн боловч дээрх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар ямар нэгэн төлөвлөгөө гаргаагүй, зөвлөмжийн хэрэгжилтийг ОӨУБЕГ-т хүргүүлээгүй байна.

ОӨУБЕГ-аас хийсэн хяналтаар илэрч байгаа зөрчил дутагдал, аудитаар дахин давтагдаж байгаа нь дотоод хяналтыг оновчтой үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байгааг илэрхийлж байна.

Өргөдөл гомдлын мэдээг сар бүрийн 5-наар тасалбар болгож ОӨУБЕГ-т хүргүүлж байна.

Нийт өргөдөл гомдлыг утга агуулгаар нь жагсаавал:

Хүснэгт 4:

Үзүүлэлт	2016 он	2017 оны эхний хагас жил		
	тоо	%	тоо	%
Иргэний бүртгэлийн чиглэлээр	72	37,6	21	36,2
Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр	17	8,9	7	1,2
Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр	3	1,6	2	3,4
Бүртгэлийн хяналттай холбоотой	59	30,8	24	41,3
Иргэний цахим үнэмлэхтэй холбоотой	13	6,8	1	1,7
Ажлын байр болон албан хаагчидтай холбоотой	26	13,6	0	0
Албан хаагчдын ёс суртахуунтай холбоотой	1	0,5	3	5,1
Нийт	191	100	58	100

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 2016 онд нийт ирсэн өргөдлийн 6-г бусад байгууллагад шилжүүлсэн, 170-г хугацаандаа шийдвэрлэсэн байна. 5 иргэнтэй холбоотой гомдол ирүүлснийг хугацаанд нь шийдвэрлэж хүргүүлсэн байна.

2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 58 өргөдөл гомдол ирүүлснээс 24 өргөдлийг шалгаж, хяналтын байцаагчийн дүгнэлт гаргасан, 5 гомдлыг шалгаж шийдсэн ба ажилчдын ёс зүйтэй холбоотой 3 гомдлоос 1-ийг хянаж сануулах арга хэмжээ авсан, 2 албан хаагчидтай холбоотой асуудлыг ОӨУБЕГ-ын ёс зүйн хороонд хүргүүлсэн байна.

Хэлтсийн үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлын талаар:

Улсын бүртгэлийн үйлчилгээний талаар иргэдэд мэдээллийг цогц байдлаар хүргэхийн тулд бүрдүүлэх баримт материалын жагсаалт болон үйлчилгээний хураамж, тэмдэгтийн хураамжийг хаана, ямар дансанд тушаах талаарх мэдээллийг ил тод байрлуулан иргэдэд хүргэж хэвшсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Улсын бүртгэлийн хэлтэс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, нийтэд ил тод мэдээлсэн байна.

Бүлэг 2: Иргэний, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хугацаанд нь үзүүлж хэвшсэн байна.

ОӨУБЕГ-ын хяналт шалгалтаар 2016 онд иргэний бүртгэлийн чиглэлээр 123 бүртгэлийг шалгаснаас 34 бүртгэл алдаатай бүртгэгдсэн, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 240 бүртгэлийг шалгаснаас 13 бүртгэл алдаатай бүртгэгдсэн зөрчил тус тус илэрсэн байна. Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 34 бүртгэлийг шалгаснаас алдаатай бүртгэгдсэн зөрчил илрээгүй байна.

2016 он, 2017 оны эхний улирлын байдлаар иргэний эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр дараах үйлчилгээг үзүүлсэн байна.



2.1 Иргэний, эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг хууль, журамд заасан хугацааны дотор бүртгэж хэвшсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн даргын томилсон ажлын хэсэгтэй хамтран хийсэн хяналт шалгалтаар аймгийн улсын бүртгэлийн архиваас иргэний, эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нийт 2327 хувийн хэргийг түүвэрлэн шалгасан болно. Хуулийн этгээдийн чиглэлээр: *Хүснэгт 5:*

№	Огноо	Хуулийн этгээдийн бүртгэлийн төрөл	Түүвэрт хамрагдсан бүртгэлийн тоо	Үйлчилгээг хугацаандаа үзүүлсэн эсэх	
				Тийм	Үгүй
1	2016 он	Шинээр бүртгүүлэх	22	22	0
2		Бүртгэлд өөрчлөлт оруулах	43	43	0
3		Лавлагаа авах	24	24	0
4	2017 он	Шинээр бүртгүүлэх	31	31	0
5		Бүртгэлд өөрчлөлт оруулах	11	11	0
6		Лавлагаа авах	27	27	0
Нийт дүн			158	158	0

Хуулийн этгээдийн бүртгэлийн тухайд үйлчилгээг хуульд заасан хугацаанд үзүүлсэн байна. Хуулийн этгээдийн бүртгэлийн бүрдүүлбэртэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ❖ Хуулийн этгээдийн 2016 оны бүртгэлд өөрчлөлт оруулан гишүүн нэмж, хасахад програмын алдаанаас болж хүний тоо зөрүүтэй бүртгэгдсэн 3 зөрчил.
- ❖ Хуулийн этгээдийн 2016 оны бүртгэлд өөрчлөлт оруулан гишүүд нэмэхэд өөрчлөлт орсон дүрмийн санг аваагүй дутуу бүрдүүлбэртэй 4 зөрчил.

Мөрөн, Бүрэнтогтох, Тариалан, Ханх сумдын иргэний улсын бүртгэлийн 2016 оны 8 төрөл тус бүрт нийт 2019 бүртгэлийг түүвэр хийн шалгахад үйлчилгээг хуульд заасан хугацаанд үзүүлсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний хувьд энгийн болон яаралтай гэсэн ялгавар тогтоож, тухайн хугацаанд нь үйлчилгээг үзүүлсэн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт6:

№	Эд хөрөнгийн бүртгэлийн төрөл	Түүвэрт хамрагдсан бүртгэлийн тоо	Үйлчилгээг хугацаандаа үзүүлсэн эсэх		Зөрчлийн тайлбар
			Тийм	Үгүй	
1	Лавлагаа /Үл хөдлөх/	14	14	-	Зөрчилгүй байна.
2	Барьцаа /Үл хөдлөх/	12	12	-	Зөрчилгүй байна.
3	Анхны бүртгэл /Үл хөдлөх/	30	30	-	Зөрчилгүй байна.
4	Анхны бүртгэл /Газар/	30	30	-	Зөрчилгүй байна.
5	Гэрээ /Газар/	17	17	-	Зөрчилгүй байна.
6	Зээлийн барьцаа	47	47	-	Зөрчилгүй байна.
Нийт дүн		150	150	-	Зөрчилгүй байна.

Иргэний болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний хувьд энгийн болон яаралтай гэсэн хугацаан ялгаварлалт байхгүй, тухайн иргэн аж ахуйн нэгжүүд хууль, журамд заасан холбогдох баримт материалуудыг бүрэн бүрдүүлж ирсэн тухай бүрд үйлчилгээг үзүүлж хэвшсэн байна.

2.2 Үйлчилгээний хураамжийг тогтоосон хэмжээгээр ногдуулж, төвлөрүүлсэн байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжийг Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолоор батлагдсан хувь хэмжээгээр тооцож байгаа эсэхийг шалгахад дараах байдалтай байна.

1. Хуулийн этгээдийн 2016, 2017 онуудын бүртгэлээс шинээр бүртгүүлэх 53, лавлагаа 51, өөрчлөлт оруулсан 54 нийт 158 бүртгэлийг түүвэрлэн шалгахад хураамжийг тогтоосон хэмжээгээр ногдуулж, төвлөрүүлсэн байна.
2. *Иргэний бүртгэлийн тухайд:* 2016 оны 8 төрлийн бүрдүүлбэр, шилжилт хөдөлгөөн, иргэний үнэмлэх, гадаад паспортын бүртгэлүүдээс Мөрөн сумын 1491, Тариалан сумын 150, Ханх сумын 154, Бүрэнтогтох сумын 224 нийт 2019 бүртгэлийг түүвэрлэн шалгахад Мөрөн сумын №22 дахь бүртгэлд цагдаагийн тодорхойлолт аваагүй, Бүрэнтогтох сумын 2016 оны гэрлэлтийн бүртгэлийн үйлчилгээний хураамж 70,0 мянган төгрөг тушаасан баримт байхгүй, төрсний бүртгэл бүртгэхдээ эцэг тогтоолтын маягт аваагүй 25,0 мянган төгрөгийн үйлчилгээний хураамж тушаасан баримт байхгүй, ОНӨ-ийн бүртгэлийн 5.0 мянган төгрөг тушаагаагүй, үрчлэлтийн бүртгэлийн 22,5 мянган төгрөг тушаасан баримт байхгүй зэрэг зөрчлүүд илэрлээ. Аудитаар хураамж тушаасан анхан шатны баримтгүй бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн Бүрэнтогтох сумын улсын бүртгэгч Б.Батмягмарт 122.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов. 2017 оны иргэний 8 төрлийн бүртгэлийн ИУБ маягт 80, иргэний бүртгэлийн лавлагаа 71,

иргэний үнэмлэх олголтын ИУБ-31 маягт 40-ийг тус тус татан авч шалгахад зөрчилгүй байна.

3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 2016 он, 2017 оны эхний улирлын байдлаар үзүүлсэн үйлчилгээний хувийн хэргээс түүвэр хийн шалгахад дараах зөрчил илэрлээ. *Хүснэгтээр харуулбал:*

Хүснэгт 7:

№	Эд хөрөнгийн бүртгэлийн төрөл	Түүвэрт хамрагдсан бүртгэлийн тоо	Хураамж тушаасан эсэх /мян.төг/		Зөрчлийн тайлбар
			Тийм	Үгүй	
1	Лавлагаа /Үл хөдлөх/	14	135.0	-	Зөрчилгүй байна.
2	Барьцаа /Үл хөдлөх/	12	290.9	-	Зөрчилгүй байна.
3	Анхны бүртгэл /Үл хөдлөх/	30	116.0	-	Зөрчилгүй байна.
4	Анхны бүртгэл /Газар/	30	60.0	-	Зөрчилгүй байна.
5	Гэрээ /Газар/	17	288.5	27.0	1 бүртгэлийн хураамжийн 27.0 мянган төгрөгийг дутуу авсан байна.
6	Зээлийн барьцаа	47	10724.3	1253,9	1. Улсын бүртгэгч Б.Мягмарсүрэн нь 1096.0 мянган төгрөгийн үйлчилгээний хураамж дутуу авсан байна. 2. Улсын бүртгэгч Ц.Баярхүү нь 22.1 мянган төгрөгийг үйлчилгээний хураамж дутуу авсан байна. 3. Улсын бүртгэгч Н.Долгоржав нь 135.8 мянган төгрөгийн үйлчилгээний хураамж дутуу авсан байна. Яаралтай-Энгийнээр бүртгэсэн тохиолдол байна.
Нийт дүн		150	11978,2	1280.9	

МУ-ын Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоол “Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээ” –ний 7.1 “... бусад яаралтай үйлчилгээг ажлын 8 цагт багтаан үзүүлнэ” гэж заасан байхад түүвэрт хамрагдсан 47 зээлийн барьцаанаас 5 зээлийн барьцааны үйлчилгээний хураамжийг энгийнээр хүлээн авч яаралтайгаар⁵ бүртгэн **1280.9** мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн зөрчил гаргасан байна.

Гүйцэтгэлийн аудитаар нийт **1403.4** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрч, анхан шатны баримт материалыг бүрдүүлж, зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж хүргүүлж байна .

⁵ 7.3 яаралтай үйлчилгээ үзүүлэхэд үйлчилгээний хөлсний хэмжээг 2 дахин нэмэгдүүлнэ гэж заасан байна.

ДҮГНЭЛТ

1. Байгууллагын удирдлага үр дүнгийн гэрээг Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасан хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагч болон аймгийн засаг даргатай байгуулаагүй, 40.3-дахь заалтын дагуу үр дүнгийн гэрээний биелэлтийг тооцож гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулаагүй байна.
2. Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэний, эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг хуулийн дагуу явуулж, батлагдсан бүтэц, орон тоонд багтаан үйл ажиллагаа явуулж байна.
3. ОӨУБЕГ-ийн хяналтаар илэрч байгаа зөрчил дутагдал, аудитаар дахин давтагдаж байгаа нь дотоод хяналтыг оновчтой үр дүнтэй, үр өгөөжтэй хэрэгжүүлэхгүй байгааг илэрхийлж байна.
4. Иргэний, эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг хууль, журамд заасан хугацааны дотор бүртгэж хэвшсэн байна.
5. Эд хөрөнгийн улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжийг батлагдсан тарифаар тооцож аваагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Очирхуягт-т:

1. Аймгийн засаг даргатай гурвалсан гэрээ байгуулж, ажлын үр дүнг тооцон ажиллах
2. Иргэний бүртгэлийн тухайд бүрдүүлбэр болон хураамж төлсөн санхүүгийн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж байх
3. Хуулийн этгээдийн бүртгэлд өөрчлөлт хийхдээ өөрчлөлт орсон дүрмийн санг бүрдүүлбэрт хавсаргаж байх.
4. Эд хөрөнгийн бүртгэлийн тухайд зээлийн барьцааны үйлчилгээний хураамжийг тооцохдоо Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолоор батлагдсан тарифыг мөрдөж ажиллах
5. Улсын бүртгэгчдийг ажлын байрны тодорхойлолтод заасан “улсын бүртгэгчийн сургалт”-д хамруулах
6. Мөрөн сумын улсын бүртгэгчдийг сумын мэдэлд шилжүүлж, сумын удирдлагатай ажлын уялдаа холбоог сайжруулж ажиллах

Хяналтын улсын байцаагч Д.Чимэдцогзолд:

7. Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг бодитой хэрэгжүүлж, гарсан зөрчил дутагдлыг дахин давтахгүй байх, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх

Нягтлан бодогч н.Мөнхдэлгэрт:

1. Сумдын улсын бүртгэгчтэй үйлчилгээний хураамжийн тооцоог анхан шатны баримтыг үндэслэн хянаж, баталгаажуулж байх

2. Дотоод албан томилолтын зардлыг олгохдоо томилолтоор явах тухай удирдамж, ажлын дэлгэрэнгүй тайлан, гүйцэтгэсэн ажлын нотлох баримт зэргийг үндэслэн олгож байх

Архив, мэдээлэл технологи, бичиг хэргийн ажилтны үүргийг хавсран гүйцэтгэгч Э.Нарантуяад:

1. Ажилтнуудын хувийн хэргийн бүрдлийг сайжруулах.
2. Үндэсний архивын газрын 2009 оны 68 дугаар тушаалаар батлагдсан Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврыг мөрдөж ажиллах.

ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр	Төлбөр хариуцагчийн		Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн /мян.төг/
		Нэр	Албан тушаал		
1	Улсын бүртгэлийн хэлтэс	М.Очирхуяг	Дарга	Шинээр томилогдсон Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нь ерөнхий газрын даргатай 2016 онд үр дүнгийн гэрээ байгуулаагүй, 2017 онд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга нь аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж ажиллаагүй.	0
2				Ажилтнуудын хувийн хэргийн бүрдэл дутуу, шаардлага хангахгүй байна.	0
3				Нийт улсын бүртгэгчдийн ажлын байрны тодорхойлолтод “улсын бүртгэгчийн сургалтад суусан байх” гэсэн шаардлагыг тавьсан боловч нийт улсын бүртгэгч нарын 91,8% нь тус сургалтад хамрагдаагүй байна.	0
4				Үйлчилгээний хураамжийг дутуу тооцсон	27.0
5		Б.Мягмарсүрэн	Улсын бүртгэгч	МУ-ын Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоол “Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээ” –ний 7.1 “... бусад яаралтай үйлчилгээг ажлын 8 цагт багтаан үзүүлнэ” гэж заасан байхад зээлийн барьцааны үйлчилгээний хураамжийг энгийнээр хүлээн авч яаралтайгаар бүртгэн хураамжийг дутуу төвлөрүүлсэн	1069.0
6		Н.Долгоржав	Улсын ахлах бүртгэгч		135.8
7		Ц.Баярхүү	Улсын бүртгэгч		22.1
8	Бүрэнтогтох сумын улсын бүртгэгч	Б.Батмягмар	Улсын бүртгэгч	Хураамж тушаасан анхан шатны баримтын бүрдэл дутуу байна	122,5
9	Нийт				1403,4

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Тайлбар	хариу
 ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС 2017.07.01-2017.07.01 хооронд хийгдсэн Төрийн аудитын газар, ХХА-ны 2017.07.01-ийн 2017.07.01-ийн 2017.07.01-ийн 2017.07.01-ийн 2017.07.01-ийн 2017.07.01-ийн 2017.07.01-ийн 2017.07.01-ийн Тайлбар хүргүүлэх тухай Хөвсгөл аймгийн Иргэдийн тэргүүлэгчдийн хурлын захиалгаар аймгийн Аудитын газраас Улсын Бүртгэлийн хэлтсийн иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр мөрдөгдөж буй хуулийн хугацаа болон үйлчилгээний хураамжинд 2017.05.01-2017.07.01 хооронд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. ОӨУБЕГ-н дарлын 2017.08.20-ны 1/5198 тоотор чиглэл ирүүлсэний дагуу улсын Бүртгэлийн хэлтсийн дарлын 2017.08.21-ны А/05 тоот комисс томилох тушаалаар 2017.08.23-ний 9 цаг 30 минутад эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн архиваас 2016, 2017 онуудын -Анхны бүртгэлээс 30.30 -ГБЗ-н бүртгэлээс 30.30 эдгээр бүртгэл болон бусад бүртгэлийн хуулийн хугацаа болон үйлчилгээний хураамжийг шалгаллаа. Нийт бүх бүртгэлээс 150 бүртгэл үзсэнээс 47 барьцааны гэрээ үүнээс үл хөдлөхийн 4-5 газрын 1-1 нийт 8 зөрчил илэрсэн гэж үзжээ. Төний тайлангийн төсөлд зээлийн барьцааны үйлчилгээний хураамжийг энгийнээр хүлээн авч нэрлэж байгаа бүртгэл 1280.9 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн зөрчил гаргасан гэжээ. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д зааснаар Эрхийн улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдүүлгийг хүлээн авч 14 хоногийн дотор үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ гэж заасан бөгөөд мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д зааснаар Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа /цаашид ипотека гэх/-г бүртгүүлэх тухай мэдүүлгийг өмчлөгч гаргах ба улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдүүлгийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ гэж тус тус заасан байдаг ба зөрчил гаргасан гэж үзэхгүй байна. ДАРГА  У.ОЧИРХУЯТ  2017.07.01	Саналыг хүлээж авч зөвлөмж хүргүүлж байна.